

## **ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ “СПОРТЫН БАГА НААДАМ”-ЫН УДИРДАМЖ**

### **Наадмын зорилго**

Сум орон нутагт спортын хөгжлийг эрчимжүүлэх, албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дунд хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлэх, идэвхтэй дасгал хөдөлгөөнийг дэмжих, хүүхэд залуучуудад соёл урлаг, спортын арга хэмжээг нэмэгдүүлэхэд оршино.

### **Нэг. Ерөнхий зүйл**

#### **1.1. Спортын төрөл, бүрэлдэхүүн**

1. Сагсан бөмбөг /6 эрэгтэй, 6 эмэгтэй/
2. Гар бөмбөг /7 эрэгтэй, 7 эмэгтэй/
3. Олс таталт /5 эрэгтэй, 3 эмэгтэй/

#### **1.2. Наадмын тов**

Наадам 2016 оны 09 сарын 24, 25-ны амралтын өдрүүдэд 09<sup>00</sup> цагаас Уурхайчдын спорт зааланд явагдана.

1. Сагсан бөмбөг, олс таталтын тэмцээн 09 сарын 24-ны өдрийн 09<sup>00</sup> цагт
2. Гар бөмбөгийн тэмцээн 09 сарын 25-ны өдрийн 09<sup>00</sup> цагт

#### **1.3. Техникийн зөвлөгөөн**

Техникийн зөвлөгөөн нь 2016 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 17<sup>30</sup> цагт Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд болно. Тус техникийн зөвлөгөөнд албан байгууллага, ААН-ийн дарга, захирал, эрхлэгч, багийн ахлагч нар оролцоно.

Техникийн зөвлөгөөн дээр тухайн тэмцээний тоглолтын дэг журмыг хэлэлцэнэ.

Техникийн зөвлөгөөнд багийн ахлагч нар тэмцээнд оролцох баг тамирчдын мэдүүлгийг маягтын дагуу ирүүлэх ба мэдүүлгийн маягтыг хавсаргав. Багийн мэдүүлэг ирүүлэхдээ тамирчдын цахим үнэмлэхний хуулбарыг хавсаргана.

#### **1.4. Тэмцээний нээлт, хаалтын үйл ажиллагаа**

Тэмцээний нээлт 09-р сарын 25-ны өдөр 12<sup>00</sup> цагт Уурхайчдын спорт зааланд хийх тул үйл ажиллагаанд баг тамирчид жигд хувцас, логотой оролцоно. /Багууд хаягтай жагсана./

### **Хоёр. Тэмцээн зохион байгуулах, дүгнэх журам**

- 2.1.Тэмцээнд оролцох баг тамирчдыг ахалсан багийн ахлагчтай байна.
- 2.2.Тэмцээний үеэр ямар нэгэн маргаан гарсан тохиолдолд тамирчид багийн ахлагчаар дамжуулан тухайн маргааныг шийдвэрлүүлнэ.
- 2.3.Тэмцээнд оролцох баг тамирчдыг тухайн байгууллагын дарга, захирал, эрхлэгч нар хариуцан идэвхтэй оролцуулж, удирдана.
- 2.4. Баг тамирчдын хувцаслалтын байдлыг дүгнэн тэмцээн тус бүр дээр 0-1 баллын оноог ерөнхий шүүгч өгнө.
- 2.5.Тэмцээнд оролцох тамирчдын мэдүүлгийг маягтын дагуу бичиж өгнө.
- 2.6. Тоглолтын дэг, хуваарь, эхлэх болон дуусах дарааллыг техникийн зөвлөгөөн дээр сугалаагаар тогтооно. Сугалаа сугалснаас хойш тэмцээнд өөр баг нэмж оруулахгүй.
- 2.7. Сагсан бөмбөг, гар бөмбөгийн тэмцээнд оролцогч багуудыг А, В, С хэсгүүдэд хувааж тойргоор тоглолт явуулан байруудыг тодорхойлох ба хэсэг тус бүрээс эхний байранд орсон багийг дараагийн шатны тоглолтонд оролцуулна.
- 2.8. Дараагийн шатанд шалгарсан багийг олимпийн системээр тоглуулж, төрөл тус бүрт аваргыг шалгаруулж, байр эзлүүлнэ.
- 2.9. Хэрэв тэмцээнд цөөн тооны баг оролцохоор бол техникийн зөвлөгөөн дээр ямар системээр тоглохыг шийдвэрлэнэ.
- 2.10. Тэмцээнд ЕБС-ийн сурагч, тус суманд харъяалалгүй, мэргэжлийн зэрэгтэй тамирчдыг оролцуулахгүй.
- 2.11. Тэмцээнд харъяалалгүй боловч ажлын онцлогийн дагуу суманд 3-аас дээш жил оршин суусан иргэдийг оролцохыг зөвшөөрнө.
- 2.12. Тэмцээнд оролцох баг тамирчид энгэрийн болон арын хувийн дугаар бүхий тоглолтын жигд өмсгөлтэй, цаг хугацаа болон тэмцээний зохион байгуулалтын шаардлагыг биелүүлэх, нээлтийн болон хаалтын үйл ажиллагаанд бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцох, хаяг, логотой байх зэрэг шаардлагуудыг хангасан байна.

2.13. Тэмцээнд өөр хүн оролцуулсан тохиолдолд оролцсон төрлийг хүчингүй болгож багийн онооноос хасаж тооцно. Тэмцээн эхлэхэд талбайдаа бэлэн байх шаардлагатай ба 5 минутанд талбайд гараагүй багт 0 оноо өгнө.

### **Гурав. Тэмцээнд оролцох багийн бүрэлдэхүүн, заавар**

3.1. Спортын бага наадамд албан байгууллага, ААН-үүд сагсан бөмбөг, гар бөмбөгийн тэмцээнд эрэгтэй 14, эмэгтэй 14 багт хуваагдаж тоглох ба дараах багийн бүрэлдэхүүнтэй оролцоно.

Үүнд:

1. ЗДТГ, Соёлын төв
2. “Шивээ-Овоо” ХК
3. “Шивээ сервис” ХХК
4. 3-р цэцэрлэг, “Илчлэг шивээ” ОНӨҮГ
5. 3-р сургууль
6. Эрүүл мэндийн төв, Цагдаагийн хэсэг
7. 1-р баг
8. 2-р баг
9. 21, 22-р зөрлөг
10. Хаан банк, Төрийн банк, ЦШС, Холбооны салбар
11. “Оргил” худалдааны төв, бусад лангуу түрээслэгчид
12. Хувийн хэвшил
13. Ахмадын хороо
14. “Бүжинхэн бүл” цэцэрлэг

3.2. Спортын наадамтай холбоотой мэдээллийг Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтний 99038561 дугаараас лавлаж болно.

### **Дөрөв. Шагнал, урамшуулал**

4.1. Тэмцээний төрөл тус бүрд нэг, хоёр, гуравдугаар байр эзлүүлж байр эзэлсэн багуудад медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал олгоно.

4.2. Гурван төрлийн нийлбэр дүнг их онооны системээр дүгнэн тэргүүн байрыг шилжин явах цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар, 2-р байр эзэлсэн багийг өргөмжлөл, мөнгөн шагналаар, 3-р байр эзэлсэн багийг өргөмжлөл, мөнгөн шагналаар тус тус шагнана.

